



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/137


Улаанбаатар хот

Хот байгуулалтын кадастрын цахим системд  
том масштабтай байр зүйн зураг оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Барилга хот байгуулалтын сайдын 2019 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 74 дүгээр тушаалаар батлагдсан Байр зүйн болон дэвсгэр тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг хөтлөх журмын 2.2, 3.1, 3.2, 4.1, 4.2 заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Том масштабын байр зүйн дэвсгэр тоон зургийг Хот байгуулалтын кадастрын /www.urban.gov.mn/ цахим системээр дамжуулан бүртгэсүгэй.
2. Том масштабын байр зүйн дэвсгэр тоон зургийг хот байгуулалтын кадастрын /www.urban.gov.mn/ цахим системд илгээхийг геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд, байр зүйн дэвсгэр тоон зургийг хянах, баталгаажуулах, зургийн санг хөтлөхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт тус тус үүрэг болгосугай.
3. Цахим системийн үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Геодези, зураг зүйн хэлтэс /Д.Мөнхцэцэг/, Хот байгуулалтын хэлтэс /Б.Одбаатар/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ж.БАТСАЙХАН

1523010708

Handwritten text, possibly a signature or date, located in the center of the page. The text is faint and difficult to decipher.

Бонд-...  
Хувь: 81.019527